



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/09

Өлгий

Г Хариуцлагатай жижүүр томилж Г
ажиллуулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67,5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4 дэх заалт, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт, Засгийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн “Ажил амралтын цагийг зохицуулах тухай” 22 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн “Сар шинийн баярын өдрүүдэд онцгой байдлын өндөржүүлсэн бэлэн байдлыг хангах, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах “Хариуцлагатай шуурхай алба” ажиллуулах тухай” 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийтээр тэмдэглэх баярын өдөр болох Монгол үндэстний уламжлалт баяр-Цагаан сарын нийтээр тэмдэглэх баярын 2026 оны 02 дугаар сарын 17-22-ны өдрүүдэд хариуцлагатай жижүүр хийх Эрүүл мэндийн газрын эмч, мэргэжилтнүүдийн хуваарийг нэгдүгээр, хариуцлагатай жижүүрийн ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Харьяа эрүүл мэндийн байгууллагуудаас нөхцөл байдлын мэдээлэл авч, бэлэн байдлыг ханган ажиллахыг Эрүүл мэндийн дүн бүргэл хариуцсан ажилтан /Х.Айгүл/-д үүрэг болгосугай.

3. Хариуцлагатай жижүүрийн утсанд ирсэн санал хүсэлт, гомдлыг хүлээн авч, холбогдох газар, хэлтсийн ахлах мэргэжилтэн болон ЭМГ-ын даргад мэдээ өгч, удирдамжийн дагуу ажиллахыг хариуцлагатай жижүүр хийж, үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдад үүрэг болгосугай.

4. Уг тушаалын хэрэгжилт, эмч, мэргэжилтнүүдийн үүрэг гүйцэтгэлийн байдалд өдөр тутам хяналт тавьж ажиллаж, дүнг 2026 оны 02 дугаар сарын 23-ны

4. Уг тушаалын хэрэгжилт, эмч, мэргэжилтнүүдийн үүрэг гүйцэтгэлийн байдалд өдөр тутам хяналт тавьж ажиллаж, дүнг 2026 оны 02 дугаар сарын 23-ны өдөр нэгтгэн танилцуулахыг ЭТХ-ийн ахлах мэргэжилтэн /Х.Анжелика/, ХШҮМХ-ийн ахлах мэргэжилтэн /А.Ерганат/ нарт даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ ~~Х.ДАУЫРЖАН~~



Эрүүл мэндийн газрын даргын
2026 оны 2 дүгээр сарын 16 өдрийн
А/09 тушаалын нэгдүгээр хавсралт



2026 оны 02 дугаар сарын 17 -ны өдрөөс 2026 оны 02 дугаар сарын 23- ны өдөр
хүртэл жижүүрээр ажиллах албан хаагчдын хуваарь

№	Албан тушаалтны нэр	Албан тушаал	Жижүүрээр ажиллах өдөр, цагаар	Утасны дугаар	Хяналт тавих хэлтсийн дарга нар
1	А.Динкелди	Ажилтан	2026.02.17 08:00-16:00	99419525	Мэргэжилтэн А.Динкелди
2	М.Халайык	Ажилтан	2026.02.17 16:00-00:00	80990544	
3	Ж.Галия	Байцаагч	2026.02.18 00:00-08:00	99926414	
4	Ш.Лена	Ажилтан	2026.02.18 08:00-16:00	99908222	
5	К.Жандаулет	Мэргэжилтэн	2026.02.18 16:00-00:00	99418342	
6	Б.Гүлбану	Байцаагч	2026.02.19 00:00-08:00	99425481	Ажилтан Ш.Аманбол
7	З.Атина	Ажилтан	2026.02.19 08:00-16:00	95113175	
8	Ш.Аманбол	Ажилтан	2026.02.19 16:00-00:00	99425481	
9	Т.Ердаулет	Ажилтан	2026.02.20 00:00-08:00	99605269	Мэргэжилтэн Ж.Нурбота
10	Х.Анжелика	Мэргэжилтэн	2026.02.20 08:00-16:00	95429562	
11	С.Сунхар	Мэргэжилтэн	2026.02.20 16:00-00:00	99425022	
12	С.Бекет	Ажилтан	2026.02.21 00:00-08:00	94117016	
13	И.Айнагүл	Мэргэжилтэн	2026.02.21 08:00-16:00	99849194	
14	Т.Нурсауле	Мэргэжилтэн	2026.02.21 16:00-00:00	99427723	

15	А.Ерганат	Мэргэжилтэн	2026.02.22 00:00-08:00	94443336	ХШҮМХ-ийн ахлах мэргэжилтэн А.Ерганат
16	Х.Ахтилек	Байцаагч	2026.02.22 08:00-16:00	95419281	
17	Т.Рахат	Мэргэжилтэн	2026.02.22 16:00-00:00	95573535	
18	Х.Еркеш	Байцаагч	2026.02.23 00:00-08:00	99420705	

Эрүүл мэндийн газрын даргын
2026 оны 02 дүгээр сарын 16 өдрийн
А/09 тушаалын хоёрдугаар хавсралт

ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Нийтлэг зүйл.

Улирлын томуугийн үе, байгалийн болон хүний буруутай үйл ажиллагаатай холбоотой гамшиг, осол, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, өвөлжилтийн бэлэн байдалд анхаарч ажиллах, гарч болзошгүй хүндрэл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, хяналтыг сайжруулах болон нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд бэлэн байдлыг ханган ажиллах

1. Хугацаа:

- 2026 оны 02 дугаар сарын 17-ны 00:00 цагаас
- 2026 оны 02 дугаар сарын 23-ны 08:00 цаг хүртэл

2. Жижүүрийн ажиллах цаг:

- Өглөөний 08:00 цагаас 16:00 цаг хүртэл
- 16:00 цагаас шөнийн 00:00 цаг хүртэл.
- 00:00 цагаас өглөөний 08:00 цаг хүртэл

3. Зорилго: Эрүүл мэндийн байгууллагуудын хариуцлага, хяналтыг сайжруулах

4. Зорилт:

- 4.1. Эх, хүүхдийн төрөлт, нас баралт,
- 4.2. Томуу, томуу төст өвчлөл,
- 4.3. Халдварт өвчин,
- 4.4. Гэнэтийн осол гэмтэл, цас, зуд, шуурга, олныг хамарсан өвчлөл,

хордлого, эндэгдлийн байдалд хяналт тавьж, аймгийн хэмжээний мэдээ гаргаж, мэдээлэх, нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд бэлэн байдлыг ханган ажиллах,

5. Жижүүрийн үйл ажиллагаа:

- 5.1. Хариуцлагатай жижүүр нь нэгдүгээр хавсралтад заасан хуваарийн дагуу жижүүрийн үүрэгт ажлыг гүйцэтгэнэ.